

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ (шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль тогтоомж

2.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсад байрладаг болон Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн орлогод албан татвар ногдуулах харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“бараа” гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.2.“үл хөдлөх эд хөрөнгө” гэж Иргэний хуулийн 84.3, 86.2-т заасныг;

4.1.3.“биет бус хөрөнгө” гэж Иргэний хуулийн 84.5-д заасан эдийн бус хөрөнгийг;

4.1.4.“аж ахуйн нэгж” гэж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч ашиг олох зорилготой бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон гадаад, дотоодын хуулийн этгээдийг;

4.1.5.“суутган төлөгч” гэж Татварын ерөнхий хуулийн 5.1.13-т заасныг;

4.1.6.“удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын хуулийн этгээд” гэж доорх шалгуурын хоёр болон түүнээс дээшхийг хангасан гадаадын хуулийн этгээдийг хэлнэ:

4.1.6.а.хувьцаа эзэмшигчдийн 50–иас дээш хувь нь Монгол Улсад оршин суудаг;

4.1.6.б.Хувьцаа эзэмшигчдийн хурлын нийт тооны 50-иас дээш хувь нь Монгол Улсад зохион байгуулагддаг;

4.1.6.в.Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн баримтыг Монгол Улсад хадгалдаг;

4.1.6.г.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 25-аас доошгүй хувь нь Монгол Улсад оршин суудаг;

4.1.6.д.нийт борлуулалтын орлогын 60-аас доошгүй хувийг Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олдог.

4.1.7.“Монгол Улсад олсон орлого” гэж албан татвар төлөгчийн Монгол Улсад олсон бүх төрлийн орлогыг;

4.1.8.“Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого” гэдэгт албан татвар төлөгчийн олсон дараах орлогыг хэлнэ;

4.1.8.а.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсад борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого;

4.1.8.б.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, эсхүл төлөөний газраас төлсөн төлбөр;

4.1.8.в.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсад зохион байгуулсан урлаг, соёл, спортын болон бусад арга хэмжээнээс олсон орлого;

4.1.8.г.Төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсад байрладаггүй аж ахуйн нэгжид тухайн төлөөний газраас шилжүүлсэн орлого;

4.1.8.д.төлөөний газрын үйл ажиллагаанд ашиглагдах хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, түрээсэлснээс олсон Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн орлого;

4.1.8.е.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн төлөөний газрын эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө борлуулсан, шилжүүлснээс олсон орлого;

4.1.8.ё.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улс дахь эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлснээс олсон орлого;

4.1.8.ж.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч өөрийн эзэмшдэг Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн хувьцаа борлуулсан, шилжүүлснээс олсон орлого;

4.1.8.з.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчөөс Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид олгосон ногдол ашгийн орлого;

4.1.8.и.төрийн болон нутгийн захиргааны байгууллага, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, төлөөний газраас Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид төлсөн, шилжүүлсэн энэ хуулийн 10.4-д заасантай холбогдох хүүгийн төлбөр;

4.1.8.й.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид төлсөн эрхийн шимтгэлийн төлбөр, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний төлбөр;

4.1.8.к.Газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн Монгол Улсад байрладаггүй эцсийн эзэмшигч өөрийн хувьцаа, хувь оролцоог бусдад борлуулах, шилжүүлэх замаар олсон эрх борлуулсны орлого;

4.1.8.л.эдгээртэй адилтгах бусад орлого.

4.1.9.“гадаад улсад олсон орлого” гэж энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгч, төлөөний газрын энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д зааснаас бусад орлого;

4.1.10.“ёслол, хүндэтгэлийн арга хэмжээний зардал” гэж:

4.1.10.а.аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд бизнесийн харилцаа шинээр тогтоох, хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилгоор зочид, төлөөлөгчдийг хүлээн авахад зарцуулсан тээврийн зардал, хүлээн авалт, зочид буудал, зоогийн газрын зардал болон орчуулагчийн хөлс;

4.1.10.б.төлөөлөн удирдах зөвлөлийн болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай шууд холбогдон гарсан тээврийн зардал, зочид буудал, зоогийн газрын, бичиг хэргийн зардал болон орчуулагчийн хөлс.

4.1.11.“хайгуулын зардал” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.6, Газрын тосны тухай хуулийн 4.1.8-д заасан үйл ажиллагаа хийхтэй холбогдон бодитой гарсан зардал;

4.1.12.“адил төрлийн бараа, ажил, үйлчилгээ” гэж физик, химийн шинж чанар, зах зээл дэх нэр хүнд болон гарал үүслээрээ ижил бараа, ажил, үйлчилгээг;

4.1.13.“нэг төрлийн бараа, ажил, үйлчилгээ” гэж шинж чанарын хувьд төстэй, иж бүрдлийн хувьд ялгаатай ч орлон гүйцэтгэх боломжтой болон нэг бүлэгт хамааруулж болох бараа, ажил, үйлчилгээг хамааруулна. Үүнийг тодорхойлохдоо тэдгээрийн чанар, барааны тэмдэг, зах зээл дэх нэр хүнд, гарал үүсэл зэргийг харгалзан үзнэ;

4.1.14.“харьцуулагдах байдлын шинжилгээ” гэж нь харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний нөхцөлийг харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулан шалгаж байгаа хүчин зүйлсийн нөлөө, зөрүүг арилгаж үнэн зөв залруулга хийж болохыг тооцож хийсэн шинжилгээний аргыг;

4.1.15.“эдийн засгийн өгөөж олох” гэж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зардал хэмнэх, хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал, хугацааг багасгах замаар ашиг буюу ашигт ажиллагааг дээшлүүлсэн байхыг;

4.1.16.“хяналтад байгаа ажил гүйлгээ” гэж харилцан хамаарал бүхий талууд хооронд хийгдсэн ажил гүйлгээг;

4.1.17.“хяналтаас гадуурх ажил гүйлгээ” гэж харилцан хамааралгүй талуудын хооронд хийсэн ажил гүйлгээг;

4.1.18.“дотоод харьцуулалт хийх ажил гүйлгээ” гэж харилцан хамаарал бүхий этгээдээс харилцан хамааралгүй болон бие даасан этгээдтэй хийсэн ажил гүйлгээг;

4.1.19. “гадаад харьцуулалт хийх ажил гүйлгээ” гэж харилцан хамааралгүй этгээдүүд хооронд хийгдсэн ажил гүйлгээг;

4.1.20. “гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит ашиг, алдагдал” гэж гадаад валют худалдах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөгийн тооцоог барагдуулах зэрэг ажил, гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүгийн ашиг, алдагдлыг;

4.1.21. “урт хугацаат гэрээ” гэж гэрээнд заагдсан үйл ажиллагаа эхэлснээс хойш тухайн татварын жилд дуусаагүй, эсхүл 12 сараас дээш хугацаанд үргэлжлэх бараа үйлдвэрлэл, боловсруулалт, тоног төхөөрөмж суурилуулалт, барилга угсралтын болон эдгээртэй адилтгах бусад гэрээг;

4.1.22. “үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж” гэж Монгол Улсад байрладаг татвар төлөгч нийт хувьцааны тоо хэмжээ, эсхүл саналын эрхийн 50 ба түүнээс дээш хувийг тухайн татварын жилийн аль нэг хугацаанд шууд, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшдэг гадаадын аж ахуйн нэгжийг;

4.1.23. “эцсийн эзэмшигч” гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3.1.11-т заасныг.

5 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгч

5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.

5.2. Албан татвар төлөгчийг Монгол Улсад байрладаг, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч гэж ангилна.

5.3. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:

5.3.1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж;

5.3.2. Удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж;

5.3.3. Монгол Улсад бүртгэгдсэн үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч ашиг олох зорилготой бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон аж ахуйн нэгж;

5.3.4. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж.

5.4. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:

5.4.1. Өөрийн төлөөний газраар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж.

5.4.2. Энэ хуулийн 5.4.1-д зааснаас бусад хэлбэрээр Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж;

6 дугаар зүйл. Төлөөний газар

6.1. Энэ хуулийн 5.4.1-д заасан татвар төлөгчийн үйл ажиллагааг Монгол Улсад бүрэн болон хэсэгчлэн явуулж байгаа нэгжийг төлөөний газарт хамааруулна.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан төлөөний газарт дараах нэгжийг хамруулж болно:

6.2.1. Аж ахуйг удирдан явуулж буй газар;

6.2.2.Салбар, тасаг, төлөөлөгчийн газар;

6.2.3.Албан байр;

6.2.4.Үйлдвэр;

6.2.5.Худалдаа, үйлчилгээний газар;

6.2.6.Уурхай, газрын тос буюу байгалийн хийн цооног, ил уурхай буюу ашигт малтмал олборлож буй газар;

6.2.7.адилтгах бусад газар, нэгж, байр.

6.3.Нийт 3 ба түүнээс дээш сарын хугацаанд үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт буюу суурилуулалтын объект, тэдгээртэй холбоотой барилгын болон хяналтын үйл ажиллагааг төлөөний газарт тооцно.

6.4.Нийт 3 ба түүнээс дээш сарын хугацаанд өөрийн ажиллагсад болон өөр бусад хөлсний ажилтнуудаар Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчид зөвлөх, хяналтын болон бусад үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг төлөөний газарт тооцно.

6.5.Энэ хуулийн 6.3, 6.4 заасан хугацааг харилцан хамаарал бүхий талуудын тухайн ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэхэд зарцуулах нийт хугацаагаар тооцно.

6.6.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн өмнөөс Монгол Улсад бараа борлуулах, үйлчилгээ үзүүлэх, гэрээ байгуулахтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх дараах этгээдийг төлөөний газарт тооцно:

6.6.1.Өөрийн биеэр гэрээ байгуулдаг, эсхүл Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн гэрээнд зарчмын өөрчлөлт оруулахгүйгээр тухайн гэрээ байгуулах ажлыг удирдан зохион байгуулдаг;

6.6.2.Энэ хуулийн 6.6.1-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн нэрийн өмнөөс бараа, бүтээгдэхүүнийг хадгалдаг, борлуулдаг, нийлүүлдэг.

6.7.Дараах нөхцөлийг аль нэгийг хангасан гэрээг энэ хуулийн 6.6.1-д заасан гэрээнд тооцно:

6.7.1.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн нэр дээр байгуулагдах;

6.7.2.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн эзэмшлийн, эсхүл шууд эзэмшлийн биш боловч ашиглах эрхтэй хөрөнгө шилжүүлэх, эсхүл тухайн хөрөнгийг ашиглах эрхийг бусдад олгох зорилготой;

6.7.3.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн үйлчилгээг үзүүлэх.

6.8.Энэ хуулийн 6.1-6.7 дахь хэсэгт заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч нь бусад этгээдээр дамжуулан Монгол Улсад даатгалын шимтгэл хураадаг буюу эрсдэлийн даатгал хийдэг бол түүнийг Монгол Улсад төлөөний газартай гэж үзнэ.

6.9.Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Орлого, хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай олон улсын хэлэлцээрт “Төлөөлөгчийн газар” гэснийг энэ зүйлд заасан төлөөний газартай адилтгаж үзнэ.

6.10.Төлөөний газрыг бүртгэх, бүртгэлээс хасах журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

7 дугаар зүйл. Харилцан хамаарал бүхий этгээдүүд

7.1.Харилцан хамааралтай этгээдүүдийг тодорхойлохдоо Татварын ерөнхий хуулийн 36.7 дахь хэсэгт заасныг баримтална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албан татвар ногдох орлого

8 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого

8.1.Энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

8.2.Энэ хуулийн 5.4.1-т заасан албан татвар төлөгчийн өөрийн төлөөний газраараа дамжуулан тухайн татварын жилд зөвхөн төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдон Монгол Улсад, Монгол Улсаас эх үүсвэртэй болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

8.3.Энэ хуулийн 5.4.2-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэйгээр олсон орлогод албан татвар ногдоно.

8.4.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:

8.4.1.үйл ажиллагааны орлого;

8.4.2.хөрөнгийн орлого;

8.4.3.хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

8.4.4.бусад орлого.

9 дүгээр зүйл. Үйл ажиллагааны орлого

9.1.Үйл ажиллагааны дараах орлогод албан татвар ногдоно:

9.1.1.бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого;

9.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаа явуулж олсон орлого;

9.1.3.техникийн, удирдлагын, зөвлөх болон бусад үйлчилгээний орлого;

9.1.4.үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого;

9.1.5.энэ хуулийн 9.1.1-9.1.4-д заасантай адилтгах бусад орлого.

9.2.Хүүгийн орлого олох, хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл, эсхүл үл хөдлөх эд хөрөнгө борлуулах, шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчийн хувьд эдгээр орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

10 дугаар зүйл. Хөрөнгийн орлого

10.1.Хөрөнгийн дараах орлогод албан татвар ногдоно:

10.1.1.хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;

10.1.2.эрхийн шимтгэлийн орлого;

10.1.3.ногдол ашгийн орлого;

10.1.4.хүүгийн орлого.

10.2.Энэ хуулийн 10.1.2-т заасан эрхийн шимтгэлийн орлогод дараах төлбөр хамаарна:

10.2.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

10.2.2.Патентын тухай хуульд заасны дагуу шинэ бүтээл, бүтээгдэхүүн болон ашигтай загвар ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

10.2.3.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд заасны дагуу барааны тэмдэг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

10.2.4.Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу технологи дамжуулсны төлбөр;

10.2.5.Үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилттай холбогдсон мэдээллийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

10.2.6.Үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилтын тоног төхөөрөмжийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

10.2.7.Энэ хуулийн 10.2.1-10.2.6-д заасантай адилтгах бусад эрх ашигласны болон ашиглах эрхийн төлбөр.

10.3.Энэ хуулийн 10.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувьцаа эзэмшил, нөхөрлөлийн буюу хамтран ажиллах гэрээнээс олсон мөнгөн болон мөнгөн бус орлого, ашгийн хувь, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг гэж үзэх бусад орлого хамаарна.

10.4.Энэ хуулийн 10.1.4-т заасан хүүгийн орлогод барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөнд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өр, зээл, өглөгийн нэхэмжлэлээс үүссэн орлого, харилцах болон хадгаламжийн данс, баталгаа, батлан даалт, зээл, зээллэг, бонд, бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого хамаарна.

11 дүгээр зүйл. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого

11.1.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод дараах орлого хамаарна:

11.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

11.1.2.эрх борлуулсан, шилжүүлсний орлого;

11.1.3.хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсний орлого;

11.1.4.энэ хуулийн 11.1.2, 11.1.3-т зааснаас бусад биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

11.2.Эрх борлуулсан, шилжүүлсний орлогод дараах орлогыг хамааруулна:

11.2.1.эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого;

11.2.2.хуулийн этгээд, эсхүл түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад борлуулах, шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчилж олсон орлого.

11.3. Энэ хуулийн 11.1.4-т заасан орлогод энэ хуулийн 4.1.3-т заасан эдийн бус хөрөнгө өмчлөх эрхээ бусдад борлуулсан, шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

12 дугаар зүйл. Бусад орлого

12.1.Энэ хуулийн 8.4.4-т заасан орлогод дараах орлогыг хамааруулна:

12.1.1.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдээс авсан хүү, анз /торгууль, алданги/, хохирлын нөхөн төлбөрийн орлого;

12.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаанаас хожсон орлого;

12.1.3.тухайн татварын жилд төлөөний газраас өөрийн толгой компани руу шилжүүлсэн ашиг;

12.1.4.гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит орлого;

12.1.5.энэ хуулийн 12.1.1-12.1.4-д заасантай адилтгах бусад орлого.

13 дугаар зүйл. Бодит бус үнэ хэрэглэсэн бараа, ажил, үйлчилгээний албан татвар ногдох орлогыг тодорхойлох

13.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан этгээдүүд хооронд зах зээлийн үнээс хямд, эсхүл өндөр үнээр бараа борлуулсан буюу шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол татварын алба бодит үнэ тодорхойлох журмын дагуу албан татвар ногдох орлогыг тодорхойлно.

13.2.Албан татвар төлөгч өөр бусад этгээдтэй бараа, ажил, үйлчилгээ солилцсон тохиолдолд тухайн бараа, ажил, үйлчилгээний албан татвар ногдох орлогыг бодит үнэ тодорхойлох журмын дагуу татварын алба тодорхойлно.

13.3.Бодит үнийг тогтоохдоо дараах аргуудын аль тохирохыг, эсхүл хослуулан хэрэглэнэ:

13.3.1.харьцуулагдах үнийн арга;

13.3.2.дамжуулан борлуулах үнийн арга;

13.3.3.өртөг дээр нэмэх арга;

13.3.4.ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшин тодорхойлох арга;

13.3.5.ажил гүйлгээний ашиг хуваах арга;

13.3.6.бусад арга.

13.4.Энэ хуулийн 13.1-13.3-т заасан бодит үнэ тодорхойлох, арга хэрэглэх журам, татвар төлөгчөөс шаардах мэдээллийн жагсаалт, маягт, загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, энэ хуулийн 4.1.12-4.1.19-д заасан тодорхойлолтуудад хамаарах харилцааг зохицуулна.

14 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлогыг хүлээн зөвшөөрөх

14.1.Дараах нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд албан татвар ногдох орлогыг хүлээн зөвшөөрнө:

14.1.1.албан татвар төлөгч албан татвар ногдох орлогыг мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан бол;

14.1.2.гэрээ, хэлцэлд хүлээсэн үүргийн дагуу барааг нийлүүлснээр, ажил, үйлчилгээг гүйцэтгэсэнээр, эсхүл тэдгээр гэрээ, хэлцэлд заасан нөхцөлийг хангаснаар.

15 дугаар зүйл. Урт хугацаат гэрээнд албан татвар ногдох орлогыг хүлээн зөвшөөрөх

15.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасныг үл харгалзан албан татвар төлөгчийн урт хугацаат гэрээтэй холбоотой тухайн татварын жилд хамаарах албан татвар ногдох орлогыг гэрээний гүйцэтгэлийн хувьд үндэслэн тооцно.

15.2.Энэ хуулийн 15.1-т заасан гэрээний гүйцэтгэлийн хувьд үндэслэн албан татвар ногдох орлогыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт баримтлан тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал

16 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тавигдах шаардлага

16.1.Дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно:

16.1.1.тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх;

16.1.2.албан татвар төлөгчийн үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх;

16.1.3.зардал бодитой гарсан ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримтаар баталгаажсан байх;

16.1.4.Монгол Улсад оршин суугч бус этгээдтэй холбогдон гарснаас бусад зардлын хувьд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14 заасан төлбөрийн баримт, эсхүл 16.2.1-т заасны дагуу татвар төлсөн тухай баримтаар баталгаажсан байх;

16.1.5.зардлыг тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа албан татвар төлөгч төлсөн, эсхүл төлөхөөр байх;

16.1.6.зардал гаргахтай холбогдон олгосон орлогоос хуульд заасан албан татварыг суутгаж, тайлагнасан байх.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан нөхцөлийг хангасан зардлыг доор дурдсан хязгаар, нөхцөлтэйгээр албан татвар ногдох орлогоос хасна:

16.2.1.цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, түүнтэй адилтгах төлбөрт нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;

16.2.2.сэлбэг хэрэгслийн зардлыг урсгал засварын зардалд багтаасан байх бөгөөд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй бөгөөд үүнээс хэтэрсэн урсгал засварын зардлыг их засварын зардалд тооцох;

16.2.3.сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;

16.2.4.албан татвар, төлбөр, хураамж нь төсөвт төлөхөөр тайлагнагдсан байх;

16.2.5.банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгөнд хэвийн зээлийн үлдэгдэлд байгуулсан сангийн хөрөнгө хамаарахгүй байх;

16.2.6.албан томилолтын зардал нь төрийн албан хаагчдын албан томилолтын зардлыг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх;

16.2.7.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал нь холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байх;

16.2.8.ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал нь тухайн татварын жилд Хөдөлмөрийн тухай хуулийн 21.1, 22.1-д заасан гэрээгээр ажиллаж байгаа ажиллагсдад олгосон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, хувь хүний орлогын албан татвар ногдуулсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байх;

16.3.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших болон шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг тухайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд жил тутам ижил хэмжээгээр үйлдвэрлэлийн зардалд оруулан хасаж тооцно.

16.4.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч татвар ногдох орлогоос хасагдах зардлыг тусгай зөвшөөрөл тус бүрээр тодорхойлно.

16.5.Энэ хуулийн 5.4.1-т заасан татвар төлөгч өөрийн төлөөний газрын үйл ажиллагаанд зориулан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, түрээслэхтэй холбогдон гарсан зардлыг уг хөрөнгийг төлөөний газар ашиглаж эхэлсэн өдрөөс ашиглаж дуусах өдөр хүртэлх хугацаанд энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу татвар ногдох орлогоос хасаж тооцно.

17 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасаж тооцох хүүгийн зардал

17.1.Энэ хуулийн 10.1.4-д заасан орлого олгохтой холбогдон гарсан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

17.2.Тухайн тайлант хугацаан дахь хүүгийн зардлаас хүүгийн орлогын дүнг хасаж энэ хуулийн 17.1-д заасан хасагдах зардлын хэмжээг тооцно.

17.3.Энэ хуулийн 17.2-д заасан хасагдах зардлын хэмжээ нь тайлант хугацаан дахь татвар ногдох орлогоос хүүгийн болон элэгдлийн зардлаас бусад энэ хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан хасагдах зардлыг хассан дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

17.4.Энэ хуулийн 9.2-д заасан хүүгийн орлого олох үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчид энэ хуулийн 17.1-17.2 дахь хэсэг хамаарахгүй.

17.5.Зээлийн хөрөнгөөр барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах хугацаанд уг зээлийн хүүд төлсөн төлбөрийг тухайн хөрөнгийн өртөгт оруулж тооцох бөгөөд түүнийг ашиглалтад оруулсан үеэс эхлэн зээлийн хүүд төлсөн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

17.6.Албан татвар төлөгчийн хувьцааг эзэмшдэг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөрийг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд энэ зардлыг зээл олгосон тухайн хувь хүний ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.

17.7.Энэ хуулийн 17.1-17.6 дахь хэсэг нь төлөөний газарт мөн адил хамаарна.

18 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардал

18.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцож болно:

18.1.1.бараа, материалын хэвийн хорогдол;

18.1.2.мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын орчныг бүрдүүлэх, дадлагын газрыг тоног төхөөрөмжөөр хангах, дадлагын байрыг засварласан зардал;

18.1.3.багш нарыг дадлагажуулсан зардал;

18.1.4.өөрийн захиалгаар мэргэжилтэн бэлтгүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад үзүүлсэн санхүүгийн дэмжлэг;

18.1.5.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд оруулсан хандив, хөрөнгө;

18.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор өгсөн нэг сая хүртэлх төгрөгийн хандив;

18.1.7.агаарын бохирдлыг бууруулах зорилгоор өгсөн хандив;

18.1.8.хадгаламж, зээлийн хоршооны зээлийн эрсдэлийн санд, бусад үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны болзошгүй эрсдэлээс хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө;

18.1.9.энэ хуулийн 19.1.8-д зааснаар бусад төсөвт төлөхөөр тайлагнагдсан албан татвар, төлбөр, хураамж;

18.1.10.эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл;

18.1.11.түрээслэгчийн санхүүгийн түрээсээр эзэмшиж байгаа хөрөнгийн элэгдэл;

18.1.12.Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрээлэгчийн байгаль орчныг хамгаалахад зориулан тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох төрийн байгууллагаас нээсэн тусгай санд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон энэхүү үйл ажиллагаатай холбогдон гарсан зардал;

18.1.13.Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрээлэгчийн байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын зардалд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө;

18.1.14.Спортын холбоо, спортын клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив;

18.1.15.Энэ хуулийн 18.1.1-д заасан хорогдлын хэмжээг Засгийн газар батална.

19 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал

19.1.Дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасахгүй:

19.1.1.энэ хуулийн 16.1-д заасан нөхцөл хангаагүй зардал;

19.1.2.санхүүгийн түрээсийн төлбөр;

19.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс бусдад төлсөн төлбөр, хүү, торгууль, анз;

19.1.4.ажиллагсад болон харилцагч байгууллага, хувь хүнд зориулсан амралт зугаалга, түүнтэй адилтгах бусад зардал;

19.1.5.харилцан хамааралтай талд борлуулсан хөрөнгийн гарз;

19.1.6.төлөөний газрын өөрийн толгой компанид шилжүүлсэн хүүгийн төлбөр, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний төлбөр, эрхийн шимтгэл, техникийн, удирдлагын, зөвлөх болон бусад үйлчилгээний төлбөр;

19.1.7.энэ хуульд заасан албан татвараас чөлөөлөгдөх орлого олохтой холбогдон гарсан зардал;

19.1.8.төсөвт төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийслэл хотын албан татвар болон энэ хуулийн дагуу бусдаас суутган авсан татвар;

19.1.9.гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус алдагдал;

19.1.10.барааны дахин үнэлгээний нэмэгдүүлсэн өртөг;

19.1.11.энэ хуулийн 18.1.4, 18.1.5, 18.1.6, 18.1.7, 18.1.14-д зааснаас бусад хандив, тусламжийн зардал.

20 дугаар зүйл. Элэгдэл тооцох

20.1.Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөнд элэгдлийг дараах байдлаар тооцно:

№	Хөрөнгийн бүлэг	Ашиглах нийт хугацаа /жилээр/
1	Барилга, байгууламж, газрын тохижилт	25
2	Машин, механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10
3	Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, програм хангамж	2
4	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна/	Хүчин төгөлдөр байх хугацаанд
5	Бусад хөрөнгө	10

20.2.Хөрөнгийн дахин үнэлгээний дүнд элэгдэл тооцохгүй.

20.3.Хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулна.

20.4.Эргэлтийн бус хөрөнгийг худалдан авах, барих, угсрах, тээвэрлэх болон тээвэрлэлттэй холбоотой даатгуулах зардлыг тухайн хөрөнгийг элэгдэл тооцох үнэлгээнд оруулж тооцно.

20.5.Энэ хуулийн 16.2.2-т заасан их засварын зардлыг уг хөрөнгийн үлдэгдэл өртөг дээр нэмж тооцох бөгөөд уг хөрөнгийг ашиглах үлдсэн хугацааны туршид элэгдэл тооцно.

20.6.Элэгдэл тооцох хөрөнгийн тодорхой нэг хэсэг нь албан татвар ногдох орлого олоход ашиглагдаж байвал элэгдлийг тухайн хэсэгт хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдох орлогоос хасна.

20.7.Эргэлтийн хөрөнгө, газар, бараа, материалын нөөц, уран зураг, урлал, эртний эдлэл, үнэт эдлэл, эдгээртэй адилтгах бусад эд хөрөнгөнд элэгдэл тооцохгүй.

20.8.Албан татвар төлөгч барилга байшин ба бусад хөрөнгийг хамтад нь худалдаж авсан тохиолдолд худалдан авсан үнийн дүнг худалдаж авсан хөрөнгө тус бүрт хуваарилна. Барилга, байгууламжийг буулгаж тухайн газарт шинэ барилга, байгууламж барих зорилгоор худалдаж авсан бол худалдан авсан үнийн дүнг барилгын өртөгт шингээнэ.

20.9.Албан татвар төлөгч өмчилж байгаа элэгдэл тооцох хөрөнгөө албан татвар ногдох орлого олох зорилгоор ашиглахаа бүрмөсөн зогсоовол уг хөрөнгийг үлдэгдэл өртөг, зах зээлийн үнийн аль их үнээр худалдан борлуулсан гэж үзэж албан татвар ногдуулна.

20.10.Санхүүгийн түрээсээр эзэмшиж байгаа хөрөнгийн хувьд түрээслэгч нь хөрөнгийн элэгдлийг албан татвар ногдох орлогоосоо хасаж тооцно.

20.11.Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдлийн шимтгэлийг дараагийн улирлын эхний өдрөөс эхлэн тооцно.

20.12.Барилга угсралтын шатанд байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгө болгон бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж эхэлсэн өдрийн дараагийн улирлын эхний өдрөөс эхлэн элэгдэл байгуулж эхэлнэ.

20.13.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь хайгуулын зардал, тусгай зөвшөөрлийн төлбөр, тусгай зөвшөөрөл эзэмших, болон худалдах, шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг хуримтлуулан бүртгэж, уурхайн ашиглалтын хугацаанд элэгдэл байгуулна.

20.14.Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалахад зориулан тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох төрийн байгууллагаас нээсэн тусгай санд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон энэхүү үйл ажиллагаатай холбогдон гарсан нэмэлт зардлыг энэ хуулийн 20.13-д заасан хайгуулын зардалд тооцно.

20.15.Хөрөнгө оруулалтын хуулийн 11.1.3-т заасанд нийцүүлэн хөрөнгийн элэгдлийг түргэвчилсэн аргаар тооцож болно.

20.16.Энэ хуулийн 20.15-т заасан түргэвчилсэн арга хэрэглэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

21 дүгээр зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

21.1.Албан татвар төлөгчийн татварын жилийн албан татвар ногдуулах орлогод албан татварыг ногдуулна.

21.2.Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдөх орлогыг хасаж тооцно.

21.3.Энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.4, 9.1.5, 9.2, 10.1.1, 12.1.1, 12.1.4-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс энэ хуульд заасан зардал, энэ хуулийн 23

дугаар зүйлд заасан шилжүүлэн тооцох алдагдлыг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.4.Энэ хуулийн 9.2-т зааснаас бусад тохиолдолд хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсэн үнээс уг хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.5.Энэ хуулийн 9.1.2-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс уг орлогыг олохтой холбогдон гарсан энэ хуулийн 16.1-д заасан нөхцөлийг хангасан зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.6.Дараах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдох тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно:

21.6.1.эрхийн шимтгэлийн орлого;

21.6.2.ногдол ашгийн орлого;

21.6.3.энэ хуулийн 9.2-т зааснаас бусад хүүгийн орлого;

21.6.4.энэ хуулийн 9.2-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

21.6.5.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаанаас хожсон орлого;

21.6.6.тухайн татварын жилд төлөөний газраас өөрийн толгой компани руу шилжүүлсэн ашиг;

21.6.7.энэ хуулийн 12.1.5-д заасан бусад орлого;

21.6.8.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д заасан орлого.

21.7.Энэ хуулийн 11.1.4-т заасан биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг уг хөрөнгийн шилжүүлсэн орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хасаж тодорхойлно.

21.8.Энэ хуулийн 11.1.2-т заасан эрх борлуулсан, шилжүүлсний орлогыг тухайн эрх борлуулсан, шилжүүлсэн үнэ болон эзэмших, ашиглах, худалдан авах, шилжүүлэн авахтай шууд холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр тодорхойлно.

21.9.Аж ахуйн нэгж өөрийн гаргасан хувьцаа, үнэт цаасыг анх борлуулан, шилжүүлсний орлого олсон тохиолдолд тухайн орлогын дүнгээс хувьцаа, үнэт цаасны нэрлэсэн үнийг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.10.Гадаад валютаар олсон орлого, гарсан зардлыг төгрөгт хөрвүүлэх, бүртгэх, тайлагнахдаа албан татвартай холбогдох гүйлгээ хийгдсэн өдрийн Монголбанкны албан ханшийг үндэслэнэ.

21.11.Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол түүнд ногдох хувийн албан татвар ногдуулах орлогыг албан татвар төлөгчийн эзэмшилд байгаа хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгөнд хувь тэнцүүлэн хуваарилсан орлогын дүнгээс уг хувьцаа болон хөрөнгийг анх худалдан авсан үнийг хасаж тодорхойлно.

21.12.Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах, эсхүл хадгаламж зээлийн хоршооны зээлийн эрсдэлийн сангийн албан татвар ногдох орлогоос хасагдсан зээлийг эргүүлэн төлсөн бол ийнхүү төлөгдсөн зээлийн дүнд энэ хуульд заасны дагуу албан татвар ногдуулна.

21.13.Даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн даатгалын үйл ажиллагааны нийт орлогоос эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсны дагуу тухайн жилд байгуулсан нөөцийн сан болон үйл ажиллагааны зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.14.Банк, санхүү, даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн эрсдэлийн санд хуримтлуулсан хөрөнгийн зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайлант жилийн татвар ногдуулах орлогод оруулж тооцно.

21.15.Энэ хуулийн 11.2.2-т заасан орлогыг тухайн эрх эзэмшигч, түүний эцсийн эзэмшигчийн шилжүүлсэн хувьцаа, хувь оролцооноос тухайн газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаанд хамаарах хэмжээгээр тухайн эрхийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

21.16.Энэ хуулийн 21.15-т заасан газрын ашиглах, эзэмших эрхийн үнэлгээг Газрын тухай хуулийн 38.6-д заасан үнийн шаардлагыг үндэслэн тодорхойлно.

21.17.Энэ хуулийн 21.16-т заасан орлогод албан татвар ногдуулах журам, газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.18.Энэ хуулийн 11.2.2-д заасан эцсийн эзэмшигч нь Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч бол хувьцаа борлуулсны орлого болон энэ хуулийн 21.15-21.17-т заасны дагуу ногдуулсан эрх борлуулсны орлогын зөвхөн аль өндөр дүнтэй орлогод холбогдох албан татвар ногдуулна. Бага дүнтэй орлогод албан татвар ногдуулахгүй.

21.19.Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуулийн дагуу дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрээлэгчид буцаан олгосон, эсхүл уурхай, олборлолтын цооног хаах үед гарсан байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө тусгай санд төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээс бага гарсантай холбоотойгоор буцаан олгосон хөрөнгийн дүнг тухайн татварын жилийн татвар ногдох орлогод нэмж тооцно.

21.20.Өмнөх татварын жилийн тайлангаар баталгаажсан албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага бол тухайн албан татвар төлөгч тухайн татварын жилийн 3 дугаар улиралд багтаан хүсэлт гаргасныг харьяалах татварын алба бүртгэж авсан тохиолдолд дараагийн татварын жилээс эхлэн тухайн татвар төлөгчийн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

21.21.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, эсхүл доор дурдсан үйл ажиллагаа эрхэлдэг албан татвар төлөгч энэ хуулийн 21.20-д заасан хүсэлт гаргахгүй:

21.21.1.ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах;

21.21.2.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох;

21.21.3.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;

21.21.4.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, автобензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох.

21.22.Энэ хуулийн 21.20-д заасан хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

22 дугаар зүйл. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

22.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.3} дахь хэсэгт заасны дагуу баталсан жагсаалтад багтсан улс оронд үйл ажиллагаа явуулсан энэ хуулийн 4.1.22-д заасан гадаадын аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-10.1.4 дугаар зүйлд заасан орлогын нийт дүнгээр татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

22.2.Гадаадын аж ахуйн нэгжийг энэ хуулийн 4.1.22-т заасан тодорхойлолтод хамруулах, 22.1-т заасны дагуу албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23 дугаар зүйл. Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох

23.1.Албан татвар ногдох нийт орлогоос энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан зардлыг хасаж илүү гарсан хэсгийг татварын тайлангаар гарсан алдагдал /цаашид “алдагдал” гэх/ гэнэ.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан татварын 5 жилийн албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцох ба ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг харьяалах татварын албаар баталгаажуулна.

23.3.Дараалсан татварын 5 жилийн хугацаанд хасагдаагүй үлдсэн алдагдлын дүнг цаашид албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй.

23.4.Нэгээс илүү татварын жилд алдагдал гарсан тохиолдолд алдагдал гарсан жилийн дарааллаар албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

23.5.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгжийн гадаад улс дахь төлөөний газрын алдагдлыг Монгол Улс дахь аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй.

23.6.Энэ хуулийн 16.4-д заасны дагуу тооцоход гарсан алдагдлыг дараалсан 5 жилийн зөвхөн тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой олсон татвар ногдох орлогоос хасаж тооцно.

23.7.Энэ хуулийн 16.4-тай холбогдох ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаа дууссан, цуцлагдсан, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсөн тохиолдолд алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцоходоо энэ хуулийн 23.6-г мөрдөхгүй.

23.8.Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу нэгдэх, нийлэх хэлбэрээр аж ахуйн нэгж өөрчлөн байгуулагдсан тохиолдолд

хасагдаагүй үлдсэн алдагдлын дүнг цаашид албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй.

23.9.Энэ хуулийн 23.1-д заасан алдагдалд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх татварын жилийн татварын тайлангаар гарсан алдагдал хамаарахгүй.

23.10.Чөлөөт бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг бүтээн байгуулалтын ажил дуусаж, зорилтот үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа эхэлсний дараагийн дараалсан татварын 5 жилд албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцно.

23.11.Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, баталгаажуулах журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ТАВДУГААР БҮЛЭГ **Албан татварын хувь, хэмжээ**

24 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ

24.1.Энэ хуулийн 21.3, 21.4, 21.7 дэх хэсэгт заасны дагуу тодорхойлоход 0-3 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300 сая төгрөг дээр 3 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

24.2.Энэ хуулийн 21.20-д заасны дагуу тодорхойлсон татвар ногдуулах орлогод 1 хувиар албан татвар ногдуулна.

24.3.Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна:

24.3.1.энэ хуулийн 21.6.1-21.6.3, 21.6.7, 21.8, 22.1-д заасан орлогод 10 хувиар;

24.3.2.энэ хуулийн 21.6.4-д заасан албан татвар ногдуулах орлогод 2 хувиар;

24.3.3.энэ хуулийн 21.5, 21.6.5-т заасан орлогод 40 хувиар;

24.3.4.энэ хуулийн 24.3.5, 24.3.6-д зааснаас бусад 21.6.6, 21.6.8-т заасан орлогод 15 хувиар.

24.3.5.Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлд гаргасан өрийн хэрэгсэл худалдан авсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн хүүгийн орлогод 5 хувиар;

24.3.6.Монгол Улсад байрладаг аж ахуйн нэгжийн гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлд гаргасан хувьцааг худалдан авсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид шилжүүлсэн ногдол ашгийн орлогод 5 хувиар;

24.4.Албан татвар төлөгч тухайн татварын жилд үйл ажиллагаа эрхлээгүй бол дараагийн татварын жилээс эхлэн улирал бүр 60,000 төгрөгийн тогтмол татвар төлнө.

24.5.Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд уг гэрчилгээгээр тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ **Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт**

25 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого

25.1.Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:

25.1.1.Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;

25.1.2.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д заасан ногдол ашиг;

25.1.3.Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого, сангийн хөрөнгө оруулалтын орлого;

25.1.4.газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон 24.1, 21.6.2-т заасан орлого;

25.1.5.зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого;

25.1.6.хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого;

25.1.7.хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлсний орлого;

25.2.Энэ хуулийн 25.1.4-т заасан албан татвар төлөгч өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон бөгөөд албан татвараас чөлөөлөгдсөн орлогыг гадаадад шилжүүлэх тохиолдолд мөн хуулийн 24.3.4-д заасан хувиар албан татвараас чөлөөлөгдөнө.

25.3.Чөлөөт бүсийн тухай хуульд заасан татвараас чөлөөлөх орлогыг тодорхойлох, хөнгөлөлт эдлүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.4.Энэ хуулийн 21.20-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах аж ахуйн нэгж 25 дугаар зүйлд заасан чөлөөлөлтийг эдлэхгүй.

26 дугаар зүйл. Албан татварын хөнгөлөлт

26.1.Албан татвар төлөгчийн жилийн татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг энэ хуулийн 5.3.1, 5.3.3-т заасан албан татвар төлөгчийн үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө:

26.1.1.уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;

26.1.2.согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;

26.1.3.газрын тосны бүтээгдэхүүний хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх, автобензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох;

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан татварын хөнгөлөлтийг тухайн тайлант хугацаанд албан татвар төлөгчийн тодорхойлж, хуульд заасан хугацаанд төлсөн албан татварын дүнгээс тооцож, дараагийн татварын жилд эдлүүлнэ.

26.3.Энэ хуулийн 26.1-т заасан хөнгөлөлтөд хамрагдах албан татвар төлөгчийн татварын жилийн албан татвар ногдох орлогыг тухайн жилийн албан татвар төлөгч болон түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тодорхойлно.

26.4.Энэ хуулийн 26.1-26.3 дэх хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

26.5.Дараах орлогод албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:

26.5.1.Хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагсдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох албан татварыг;

26.5.2.нийт 25-аас дээш ажилчидтай аж ахуйн нэгжийн ажилчдын 2/3 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох тухайн төрлийн албан татварыг;

26.5.3.байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварыг;

26.5.4.улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;

26.5.5.Биеийн тамир, спортын тухай хуулийн 26.2 дахь хэсэгт заасан стандартыг хангасан спортын барилга байгууламж, спортын заал, талбай, дэд бүтцийг барьж байгуулсан аж ахуйн нэгж тухайн спортын барилга байгууламж, спортын заал, талбайг ашиглаж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд ашиглалтын үйл ажиллагаанаас олсон 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;

26.5.6.хөрөнгө оруулалтын сангийн орлогод ногдох албан татварыг;

26.5.7. чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;

26.5.8. чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;

26.5.9. чөлөөт бүсэд инноваци, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг ашигт үйл ажиллагаагаа эхэлсний дараагийн дараалсан татварын 5 жилийн орлогод ногдох албан татварыг.

26.6.Энэ хуулийн 26.5.3, 26.5.4-д заасан техник, тоног, төхөөрөмж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална.

26.7.Энэ хуулийн 21.20-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах аж ахуйн нэгж 26 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг эдлэхгүй.

26.8.Албан татвар ногдох нийт орлогоос энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан хасагдах зардал, энэ хуулийн 23-д заасан алдагдлыг хасаж илүү гарсан хэсэгт энэ зүйлд заасан хөнгөлөлтийг эдлүүлнэ.

26.9.Тайлант хугацаанд албан татварын хөнгөлөлтийг тухайн орлогод ногдуулан төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.

26.10.Албан татварын хөнгөлөлтийг жилийн эцсийн татварын тайланд үндэслэн тухайн татварын жилд төлсөн татвараас буцаан олгох замаар эдлүүлнэ.

27 дүгээр зүйл. Гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох

27.1.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

27.2.Гадаад улсад ногдуулан төлсөн боловч буцаан авах боломжтой татварыг энэ хуулийн 27.1-д заасны дагуу хасаж тооцохгүй.

27.3.Гадаад улсад ногдуулан төлсөн татварын хүү, торгууль, алдангийг энэ хуулийн 27.1-д заасны дагуу хасаж тооцохгүй.

27.4.Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулахгүй орлогод ногдуулан төлсөн татварыг энэ хуулийн 27.1-д заасны дагуу хасаж тооцохгүй.

27.5.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг дараах хоёр шалгуураар тооцсон дүнгийн аль багаар тооцно:

27.5.1.Албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татварын дүн;

27.5.2.Гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар ногдох орлогод Монгол Улсын татварын хуулийн дагуу ногдуулсан тохиолдолд төлбөл зохих албан татварын дүн.

27.6.Энэ хуулийн 27.5.2-т заасан дүнг тухайн татварын жилд татвар төлөгчийн албан татвар ногдуулан төлсөн гадаад улс бүрээр тусад нь тооцно.

27.7.Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн гадаад улсад ногдуулсан албан татварыг энэ хуулийн 22.1-д заасны дагуу тодорхойлон ногдуулсан тухайн жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

27.8.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулан төлсөн татвар тухайн татвар төлөгчийн Монгол Улсад төлбөл зохих албан татварын дүнгээс илүү гарсан татварыг буцаан олгохгүй бөгөөд цаашид шилжүүлэн тооцохгүй.

27.9.Энэ хуулийн 27.1-т заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг баталгаажуулахдаа гадаад улсын эрх бүхий байгууллагад тайлагнасан татварын тайлан, тус байгууллагаас үйлдсэн татвар төлснийг нотлох баримт, эсхүл тодорхойлолтыг үндэслэнэ.

27.10.Энэ хуулийн 27 дүгээр зүйлд заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг харьяалах татварын алба баталгаажуулна.

27.11.Энэ хуулийн 27.1-д заасан гадаад улстай Монгол Улсын татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харилцан мэдээлэл солилцох эрх зүйн боломжтой байх бөгөөд эдгээр улсуудын жагсаалтыг жил бүрийн сүүлийн улиралд, жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 хоногт багтаан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шинэчлэн зарлана.

27.12.Энэ хуулийн 21.20-д заасны дагуу татварын албанд бүртгүүлсэн аж ахуйн нэгж 27 дугаар зүйлд заасны дагуу гадаад улсад ногдуулсан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцохгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Албан татвар суутгах, төсөвт төлөх, тайлагнах, буцаан олгох

28 дугаар зүйл. Албан татварыг суутган төлөх

28.1.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч энэ хуулийн 21.5, 21.6.1-21.6.5, 21.6.7, 21.8-д заасан орлогод ногдох албан татварыг суутган төлөгч ногдуулж, суутгана.

28.2.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид энэ хуулийн 21.6.8-д заасан орлогыг олгосон бол суутган төлөгч албан татварыг ногдуулж, суутгана.

28.3.Энэ хуулийн 21.15-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг тухайн эрх эзэмшигч ногдуулж, суутгана.

28.4.Энэ хуулийн 21.6.6-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг төлөөний газар ногдуулж, суутгана.

28.5.Энэ хуулийн 5.4.1-д заасан татвар төлөгч өөрийн төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдох орлогыг Монгол Улсад оршин суугч бус этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тухайн төлөөний газар холбогдох албан татварыг ногдуулж, суутгана.

28.6.Энэ хуулийн дагуу суутган төлөгчийг тодорхойлох боломжгүй бол албан татвар ногдуулах орлого олсон этгээд нь албан татварыг өөрөө тодорхойлж ногдуулна.

28.7.Суутган ногдуулсан албан татварыг ажлын 10 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.

29 дугаар зүйл. Албан татварыг өөрөө тодорхойлон ногдуулж, төсөвт төлөх

29.1.Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд энэ хуулийн 24.1-д заасны дагуу ногдуулан төлөх төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасны дагуу урьдчилан тодорхойлсны дагуу сар бүр төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор, улирлын эцэст хийсэн тооцоогоо дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцэст хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө.

29.3.Өмнөх жилд үйл ажиллагаа эрхлээгүй тухай татварын тайлан гаргасан татвар төлөгч дараа улирлын эхний сарын 20-ны дотор энэ хуулийн 24.4-д заасан хэмжээний татварыг төсөвт төлнө.

29.4.Төр нь өмчдөө ногдох ашиг болон хувьцааны ногдол ашгийг бүрэн буюу хэсэгчлэн төсөвт дайчлах эрхтэй бөгөөд хэмжээг нь Засгийн газраас тухай бүр тогтооно.

30 дүгээр зүйл. Албан татварыг тайлагнах

30.1.Жилийн албан татвар ногдох орлого нь 3 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч улирлын татварын тайланг дараагийн улирлын эхний

сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

30.2.Жилийн албан татвар ногдох орлого нь 3 тэрбум төгрөг хүртэл энэ хуулийн 21.20-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй татвар төлөгч эхний хагас жилийн татварын тайланг 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.

30.3.Энэ хуулийн 21.20-д заасны дагуу гаргасан хүсэлтээ татварын албанд бүртгүүлсэн татвар төлөгч жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

30.4.Энэ хуулийн 30.1, 30.2-т заасан албан татвар ногдох жилийн орлогыг тодорхойлохдоо албан татвар төлөгчийн зөвхөн тухайн тайлант жилийн өмнөх татварын жилд тайлагнасан албан татвар ногдох жилийн орлогын хэмжээнд үндэслэнэ.

30.5.Албан татвар төлөгч нь холбогдох татварын тайланг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргана.

30.6.Албан татвар төлөгч холбогдох татварын тайланд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу суутган ногдуулсан албан татварын тайланг хавсаргана.

30.7.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид орлого олгосон суутган төлөгч нь хувь хүн бол энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу суутган ногдуулсан албан татварын тайланг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тайлагнах албан татварын тайланд хавсаргана.

30.8.Тайлант жилд үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгч энэ хуулийн 30.2-т зааснаар татварын тайлан гаргана.

30.9.Албан татвар төлөгч үйл ажиллагаа эрхлээгүй тухай тайлан гаргасан жилийн дараагийн татварын жилээс эхлэн жилд нэг удаа, дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

30.10.Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ хуулийн дагуу тухайн татварын жилд тусгай зөвшөөрөл тус бүрт хамаарах албан татварын тайланг тус тус гаргаж, албан татварын тооцоо хийнэ.

30.11.Энэ хуулийн 28.6-д заасны дагуу тодорхойлон ногдуулсан албан татварыг албан татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд тайлагнана.

30.12.Энэ хуулийн 22 дугаар зүйлийн дагуу ногдуулсан албан татварыг гадаад улсын эрх бүхий байгууллагад тайлагнасан татварын тайлангийн хамт энэ хуулийн 4.1.22-т тодорхойлсон Монгол Улсад байрладаг татвар төлөгч энэ хуулийн 30.1, 30.2-д заасан хугацаанд тайлагнана.

30.13.Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, тайлан нөхөх заавар, зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

31 дүгээр зүйл. Үнэ шилжилтийн тайлагнал

31.1.Улс бүрээр гаргах үнэ шилжилтийн тайлангийн маягтын загвар, маягт нөхөх заавар, тайлагнах харилцааг зохицуулсан журмыг олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн стандарт, жишиг баримт бичгүүдэд нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

31.2.Улс бүрийн үнэ шилжилтийн тайланг татварын эрсдэл тооцох, статистик, тооцоо судалгааны зорилгоор ашиглах бөгөөд үнэ шилжилтийн хяналт шалгалтаар татварын ногдуулалтын тохиргоо хийхэд ашиглахгүй.

31.3.Энэ хуулийн 31.1-31.2-д заасныг үл харгалзан, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч энэ хуулийн 5.4, 7 дугаар зүйлд заасан албан татвар төлөгчтэй ажил гүйлгээ хийсэн болон хамааралтай этгээдийн мэдээллийг холбогдох маягтын дагуу жилийн эцсийн татварын тайлантай хамт дараа оны 2 дугаар сарын 28-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

31.4.Энэ хуулийн 31.3-д заасан тайлангийн маягтыг үндсэн болон туслах гэж ангилах бөгөөд маягтын загвар, маягт нөхөх заавар, тайлагнах нарийвчилсан журмыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, жишиг баримт бичгүүдэд нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32 дүгээр зүйл. Албан татварын буцаан олголт

32.1.Албан татвар төлөгч, суутган төлөгчийн энэ хуулийн 30.1, 30.2-т заасны дагуу хүргүүлсэн тайлангаарх албан татварын илүү, дутуу төлөлтийг тооцооллыг харьяалах татварын алба дараах журмаар нягталж, эцсийн тооцоо хийнэ:

32.1.1.татварын жилд албан татвар төлөгчид буцаан олгох татварын хэмжээ нь энэ хуулийн 26.9-т зааснаар хязгаарлагдана;

32.1.2.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг албан татвар төлөгч мөн хуулийн 26.9-д заасан хязгаарт багтаан өөрөө сонгон эдэлнэ;

32.1.3.албан татвар төлөгч энэ хуульд заасан хөнгөлөлтийг хэсэгчлэн эдлэхгүй;

32.1.4.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар нь төлбөл зохих албан татварын хэмжээнээс бага тохиолдолд харьяалах татварын алба албан татвар төлөгчид мэдэгдэж, эцсийн тооцоог хийнэ.

32.3.Энэ хуулийн 32.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар, төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг Татварын ерөнхий хуулийн 44.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

32.4.Энэ хуулийн 32.3-т заасан илүү гарсан дүн буюу албан татвар төлөгчийн буцаан авах илүү төлсөн татварыг дараах журмаар буцаан олгоно:

32.4.1.буцаан олголтыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан албан татвар төлөгчид буцаан олгоно;

32.4.2.харьяа татварын алба энэ хуулийн 30.1, 30.2 дугаар зүйлд заасан тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 20 өдөрт багтаан буцаан олгох татварын хэмжээг хянан тодорхойлж, харьяалах төрийн сангийн нэгжид хүргүүлнэ;

32.4.3.энэ хуулийн 32.4.2-д заасан буцаан олголтыг дараа жилийн 2 дугаар улиралд багтаан олгоно.

32.5.Энэ хуулийн 32.4-т заасан албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32.6.Буцаан олгох албан татвар нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхгүй байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад

33 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

33.1.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ